



22

УЛААНБААТАР

хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

1967 оны 8-р сарын 3-ны өдөр Дугаар 202

Улаанбаатар хот

ТЗ-ийг 1990 оны 140-р тогтоолоор хүчингүй

РАЙОНЫ ХУДАЛДААНЫ КОНТОРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ.

Улаанбаатар хотын худалдаа удирдах газрын харьяа аж ахуйн тооцоотой 4 дэлгүүрийг 1963 оны 10-р сарын нэгнээс эхлэн нэгтгэж районы худалдааны конторыг туршлагын журмаар зохион байгуулан ажиллуулж ирсэн үр дүнгээс үзэхэд районы худалдааны конторын удирдлага нь хэт төвлөрснөөс худалдааны ажлын гол хэмжүүр болох бараа гүйлгээний төлөвлөгөөг жил дараалан тасалдуулж, аж ахуй санхүүгийн үндсэн үзүүлэлт нь буурч байсны зээл тооцооны тусгай журамд байнга орж, ажиллагааны зардлыг хэтрүүлж, олох ашгийн төлөвлөгөөг тасалдуулж иржээ.

Нөгөө талаар хотыг райончилсан, засаг захиргааны зохион байгуулалтанд өөрчлөлт орсон байдалд тохирохгүй байгааг тэмдэглэж:

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас
ТОГТООХ НЬ:

I. Районы худалдааны конторыг 1968 оны I-р сарын I-нээр татан буулгаж, аж ахуйн тооцоотой аж үйлдвэрийн барааны I, хүнсний барааны 2 дэлгүүр болгон зохион байгуулан

23

ажиллуулвхыг хотын худалдаа удирдаж газар /н.ДАМДИН-СҮРЭН/-д даалгасугай.

2.Зохион байгуулалтын өөрчлөлтөөр байгуулагдах аж ахуйн тооцоотой 3 дэлгүүрийн орон тоо, цалингийн фондыг хянан үзэхийг хотын ХЦХний товчоо /н.СЭДБАВАР/-т даалгасугай.

3.1967 оны сүүлийн хагас жилийн худалдаа, аж ахуйн санхүүгийн төлөвлөгөөний зорилтуудыг бүхий л үзүүлэлтээр давуулан биедүүлэхэд худалдааны үндсэн цэг салбар, ажилчдын дунд зохион байгуулалтын удирдлагыг улам тодорхой болгон ажиллахыг районы худалдааны конторын дарга /н.БАДАРЧ/-д даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ I-Р ОРЛОГЧ ДАРГА
ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫГ

ШИРНИН
БАЛЖИННЯМ.

НИЙЛСЭН

7%-ц-Э.